

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **“Хүнд даацын автомашины дугуй”**

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112408

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **“Хүнд даацын автомашины дугуй”** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100% - иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны жилийн санхүүгийн тайлан**

Ашигтай ажилласан байх жилийн тоо: **2019, 2020 оны аль нэг жилд**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Шаардлагагүй**

Туршлага: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 онд ижил төстэй бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн туршлагатай байна.**

Тендерийн хамт **1-р багцад 6,350,000 төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ**

Тендерийг **2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 10:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхтэй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 409 тоот өрөө, утас:450060+188

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ

